

БУЛГАН АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгоны цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2025/138/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2025 он</p>	<p>Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын албан тушаалын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn</p> <p>“Бэйкер Тилли Далайван Аудит” ХХК-ийн Орхон аймаг дахь салбарын захирал: Д.Мягмарсүрэн Утас: 99030170 Цахим хаяг: dalaivan.et@gmail.com</p> <p>“Бэйкер Тилли Далайван Аудит” ХХК-ийн Орхон аймаг дахь салбарын Аудитор: Б.Пүрэвсүрэн Утас: 99921600 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

 <p>БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР</p> <p>Анхдагчдын өргөн чөлөө 1-120, Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг, 63082, Утас/Факс:7034-2580 Цахим шуудан:bulgan@audit.gov.mn</p> <p>2025.02.24 № 256</p> <p>танай _____ ны № _____ т</p>	<p>БУЛГАН АЙМГИЙН ХАНГАЛ СУМЫН ХЯЛГАНАТ ТОСГОНЫ ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ И.БУРМАА ТАНАА</p>
<p>Өөрчлөлтгүй дүгнэлт</p> <p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгоны цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p> <p>Хялганат тосгоны цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.</p> <p>Дүгнэлтийн үндэслэл</p> <p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p> <p>Асуудлыг онцолсон хэсэг</p> <p>Хялганат тосгоны цэцэрлэг нь 2024 онд 175 хүүхдийн хүчин чадалтай боловч 216 хүүхэдтэй үйл ажиллагаа явуулж, 33 хүүхэд хувилбарт хөтөлбөрт хамрагдаж гүйцэтгэлээр санхүүжсэн. Тайлант онд Боловсролын яамнаас 26,314.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй авч санхүүгийн тайланд тусгасан байна.</p> <p>Аудитын гол асуудал</p> <p>Боловсролын байгууллага гүйцэтгэлд суурилсан төсвөөр санхүүжүүлэх болсноор сургуулийн өмнөх боловсрол олгох хөтөлбөрөөс хэрэгжүүлэх арга хэмжээ 7 болж зардлын зүйл анги багасаж, ихэнх зардал бараа үйлчилгээний бусад зардлаас зарцуулах болсон байна.</p>	
<p>632502484</p>	

Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 128 тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлсийг шинэчлэн тогтоосон байна. Мөн 2024 оны 9 сарын 1-нээс Боловсрол шинжлэх ухааны сайдын 2024 оны 02 сарын 26-ны өдрийн А/85, А/34 тоот тушаалаар "Орон тооны хязгаарын жишиг норматив" батлагдсан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр нийт 7 зорилтын хүрээнд 58 арга хэмжээ хэрэгжүүлж ажиллан 98 хувьтай дүгнүүлсэн байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН
ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  - ЖЭНХЦООДОЛ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>209,005,212.69</u>	<u>262,597,770.40</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	155,106,218.69	191,984,716.40
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	155,106,218.69	191,984,716.40
3121	Төгрөг	155,106,218.69	191,984,716.40
31211	Төрийн сангийн харилцах	155,106,218.69	191,984,716.40
35	БАРАА МАТЕРИАЛ	53,898,994.00	70,613,054.00
354	Хангамжийн материал	53,898,994.00	70,613,054.00
35410	Бичиг хэргийн материал	2,085,773.00	9,586,073.00
35420	Аж ахуйн материал	32,287,325.00	32,392,325.00
35460	Хүнсний материал	4,305,490.00	8,294,300.00
35470	Бусад хангамжийн материал	15,220,406.00	20,340,356.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>371,575,992.87</u>	<u>376,342,437.50</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	371,575,992.87	376,342,437.50
392	Биет хөрөнгө	354,859,742.87	359,879,312.50
39201	Барилга, байгууламж, орон сууц	375,026,085.85	375,026,085.85
39202	Хуримтлагдсан элэгдэл	(69,513,090.92)	(81,028,528.82)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	62,404,446.20	90,548,861.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	(38,574,249.13)	(46,036,387.07)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	34,333,389.00	35,583,289.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,549,534.85)	(15,946,704.38)
39214	Бусад үндсэн хөрөнгө	12,199,096.69	12,199,096.69
39215	Хуримтлагдсан элэгдэл	(10,466,399.97)	(10,466,399.97)
393	Биет бус хөрөнгө	16,716,250.00	16,463,125.00
39301	Програм хангамж	1,350,000.00	1,350,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(843,750.00)	(1,096,875.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	16,210,000.00	16,210,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>580,581,205.56</u>	<u>638,940,207.90</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>2,369,790.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	2,369,790.00
413	Өглөг	-	2,369,790.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	2,369,790.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>580,581,205.56</u>	<u>636,570,417.90</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	580,581,205.56	636,570,417.90
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	317,794,490.00	317,794,490.00
51101	Өмч: - төрийн	317,794,490.00	317,794,490.00
512	Хуримтлагдсан үр дүн	(60,572,427.80)	(4,583,215.46)
51210	Өмнөх үеийн үр дүн	(60,572,427.80)	(60,572,427.80)
51220	Тайлант үеийн үр дүн	-	55,989,212.34
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	323,359,143.36	323,359,143.36
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>580,581,205.56</u>	<u>638,940,207.90</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	817,411,176.73	1,003,412,315.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	29,003,754.89	39,464,915.00
120	Нийтлэг татварын бус орлого	29,003,754.89	39,464,915.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,836,655.69	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	8,836,655.69	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө	582,649.20	26,314,415.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал	19,584,450.00	13,150,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	788,407,421.84	963,947,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	689,395,800.00	865,726,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	689,395,800.00	865,726,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	99,011,621.84	98,221,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	99,011,621.84	98,221,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	696,789,767.41	947,423,102.66
21	УРСГАЛ ЗАРДАЛ	696,789,767.41	947,423,102.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	696,789,767.41	947,416,757.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	404,464,654.45	627,987,274.84
210101	Үндсэн цалин	315,175,811.62	423,260,499.23
210102	Нэмэгдэл	69,403,396.28	188,987,741.53
210104	Урамшуулал	19,885,446.55	15,739,034.08
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,641,568.67	82,120,982.45
210201	Тэтгэврийн даатгал	36,935,180.51	57,173,495.40
210202	Тэтгэмжийн даатгал	4,196,616.64	6,712,121.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,317,693.41	3,377,126.87
210204	Ажилгүйдлийн даатгал	735,213.99	3,151,012.66
210205	Эрүүл мэндийн даатгал	7,456,864.12	11,707,225.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	88,411,621.84	96,415,054.71
210301	Гэрэл, цахилгаан	8,733,384.19	9,791,445.76
210302	Түлш, халаалт	74,878,237.65	79,823,608.95
210303	Цэвэр, бохир ус	4,800,000.00	6,800,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,481,550.00	-
210408	Бараа материал акалсны зардал	1,481,550.00	-
2105	Нормативт зардал	81,362,925.00	89,004,915.00
210502	Хоол, хүнс	81,362,925.00	89,004,915.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,000,000.00	1,215,000.00
210604	Урсгал засвар	11,000,000.00	1,215,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,120,000.00	1,080,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,120,000.00	1,080,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	56,307,447.45	49,593,530.37
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,073,720.00	18,832,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,161,050.00	6,133,360.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	17,072,677.45	24,627,870.37

Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгоны цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	6,345.29
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	6,345.29
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	6,345.29
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	120,621,409.32	55,989,212.34
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.96	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.96	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(0.96)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	120,621,408.36	55,989,212.34

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	788,407,421.84	963,947,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	788,407,421.84	963,947,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	689,395,800.00	865,726,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	689,395,800.00	865,726,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	99,011,621.84	98,221,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	99,011,621.84	98,221,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	664,009,994.96	923,989,002.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	664,009,994.96	923,989,002.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	664,009,994.96	923,982,657.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	404,464,654.45	627,987,274.84
210101	Үндсэн цалин	315,175,811.62	423,260,499.23
210102	Нэмэгдэл	69,403,396.28	188,987,741.53
210104	Урамшуулал	19,885,446.55	15,739,034.08
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,641,568.67	82,120,982.45
210201	Тэтгэврийн даатгал	36,935,180.51	57,173,495.40
210202	Тэтгэмжийн даатгал	4,196,616.64	6,712,121.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,317,693.41	3,377,126.87
210204	Ажилгүйдлийн даатгал	735,213.99	3,151,012.66
210205	Эрүүл мэндийн даатгал	7,456,864.12	11,707,225.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	88,011,621.84	96,415,054.71
210301	Гэрэл, цахилгаан	8,733,384.19	9,791,445.76
210302	Түлш, халаалт	74,478,237.65	79,823,608.95
210303	Цэвэр, бохир ус	4,800,000.00	6,800,000.00
2105	Нормативт зардал	81,949,250.00	90,623,935.00
210502	Хоол, хүнс	81,949,250.00	90,623,935.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,000,000.00	1,320,000.00
210604	Урсгал засвар	11,000,000.00	1,320,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,120,000.00	1,080,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,120,000.00	1,080,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,822,900.00	24,435,410.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,722,300.00	15,924,910.00

Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгоны цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,100,600.00	8,510,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	6,345.29
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	6,345.29
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	6,345.29
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	124,397,426.88	39,958,397.71
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	3,079,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	3,079,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	3,079,900.00
222001	Тоног төхөөрөмж	-	3,079,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	(3,079,900.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	124,397,426.88	36,878,497.71
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		155,106,218.69
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	155,106,218.69	191,984,716.40

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	317,794,490.00	323,359,143.36	(60,572,427.80)	580,581,205.56
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	317,794,490.00	323,359,143.36	(60,572,427.80)	580,581,205.56
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	317,794,490.00	323,359,143.36	(60,572,427.80)	580,581,205.56
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	317,794,490.00	323,359,143.36	(60,572,427.80)	580,581,205.56
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	317,794,490.00	323,359,143.36	(60,572,427.80)	580,581,205.56
D08	Тайлант үеийн үр дүн			55,989,212.34	55,989,212.34
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	317,794,490.00	323,359,143.36	(4,583,215.46)	636,570,417.90

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,020,677,354.71	927,062,557.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,020,677,354.71	923,982,657.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,020,677,354.71	923,982,657.00

Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгоны цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	701,053,200.00	627,987,274.84
210101	Үндсэн цалин	474,367,400.00	423,260,499.23
210102	Нэмэгдэл	221,492,800.00	188,987,741.53
210104	Урамшуулал	5,193,000.00	15,739,034.08
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,631,600.00	82,120,982.45
210201	Тэтгэврийн даатгал	59,589,500.00	57,173,495.40
210202	Тэтгэмжийн даатгал	7,010,500.00	6,712,121.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,505,300.00	3,377,126.87
210204	Ажилгүйдлийн даатгал	3,505,300.00	3,151,012.66
210205	Эрүүл мэндийн даатгал	14,021,000.00	11,707,225.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	96,415,054.71	96,415,054.71
210301	Гэрэл, цахилгаан	9,791,445.76	9,791,445.76
210302	Түлш, халаалт	79,823,608.95	79,823,608.95
210303	Цэвэр, бохир ус	6,800,000.00	6,800,000.00
2105	Нормативт зардал	98,903,500.00	90,623,935.00
210502	Хоол, хүнс	98,903,500.00	90,623,935.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,800,000.00	1,320,000.00
210604	Урсгал засвар	1,800,000.00	1,320,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,198,600.00	1,080,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,198,600.00	1,080,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,675,400.00	24,435,410.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,164,900.00	15,924,910.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,510,500.00	8,510,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	3,079,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	3,079,900.00
222001	Тоног төхөөрөмж	-	3,079,900.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	921,852,300.00	1,885,799,700.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	865,726,000.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	-	865,726,000.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	98,221,400.00
132001	Орон нутгийн төсвөөс	-	98,221,400.00
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	921,852,300.00	921,852,300.00
122001	Хандив тусламж /дотоод/	921,852,300.00	921,852,300.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		155,106,218.69
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		191,984,716.40

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулах алдаа илрээгүй болно. Аудитаар нийт 50,856.2 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 1,359.5 мянган төгрөгийн 4 төлбөрийн акт, 39,468.7 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 10,028.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Аудитаар залруулсан зөрчилтэй асуудлаас 13,435.8 мянган төгрөгийн тайлангаар илэрсэн зөрчлүүд нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох ба тоо хэмжээ их ч санхүүгийн тайланд нөлөөлөх магадлалгүй тул материаллаг багатай гэж үзсэн тул өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн болно.

3.1 Төлбөрийн акт

- Илрүүлэлт: Явцын аудитаар 4 бүлгийн хүүхдийн ирцийг тодорхой хоногоор тулган шалгахад бодитоор ирсэн хүүхдээс, хоолны өдөрлөгөөр ирц 157 хүүхэд илүү бүртгэж 471.0 мянган төгрөгийн хүнсний материал илүү зарлагадсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 5.1.5.хариуцлагатай байх, 41.2.7. хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах. гэсэн заалтуудыг зөрчсөн байна.
- Илрүүлэлт: Шатахууны тооцооллыг шалгахад норм нормативыг буруу тооцсон, мөн анхан шатны баримтгүй 150.0 мянган төгрөгийн шатахуун илүү зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, ЗТХС-ын 2019 оны 390 тушаалаал батлагдсан "Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-ыг баримталж ажиллаагүй байна.
- Илрүүлэлт: Явцын аудитаар биет тооллого хийхэд эцэг эх, асран хамгаалагчаас авч хэрэглэдэг сургалтын болон эрүүл ахуйн хэрэгсэл 540.0 мянган төгрөгийн дутагдалтай байсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" Боловсролын ерөнхий газрын даргын 2023 оны 1/4511 тушаалын хавсралт "улирал бүр тайлагнах" гэсэн заалтуудын хэрэгжүүлж ажиллаагүй байна.
- Илрүүлэлт: Явцын аудитаар бараа материалын дансанд биет тооллого хийхэд 198.5 мянган төгрөгийн хүнсний материал дутсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" 5.1.5."хариуцлагатай байх." 41.2.7."хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.2 Албан шаардлага

- Илрүүлэлт: Цалингийн тооцоололд сорил гүйцэтгэхэд нийгмийн даатгалын ажил мэргэжлийн кодыг буруу тооцож 291.9 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг дутуу, 225.0 мянган төгрөгийн шимтгэлийг илүү тооцож тайлагнасан байна. Хөдөлмөрийн тухай хуулийн 102.1.5.цалин хөлсийг тооцох аргачлал ил тод, ойлгомжтой байх ба Сангийн сайд, ХНХС-ын 2024 оны А/44/А/40 дугаар тушаалын "Ажил олгогч нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд бүртгэх даатгуулагчийн төрлийн код" зөрчигдсэн байна.
- Илрүүлэлт: Цалингийн тооцоололд сорил гүйцэтгэхэд ажилтны ажилласан хоногийг илүү тооцож 1,531.3 мянган төгрөгийн цалин илүү бодож олгосон байна. Эдгээр нь Хөдөлмөрийн тухай хуулийн 107.1."Ажил олгогч хуульд өөрөөр заагаагүй бол үндсэн цалинг ажлын байрны шинжилгээ, үнэлгээ,

эсхүл ажилтны ур чадварт үндэслэн цагаар, хийснээр, бусад хэлбэрээр тооцно" гэсэн заалт зөрчигдөж байна.

- **Илрүүлэлт:** Үнэ төлбөргүй хүлээн авсан 26,314.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 11,106.0 мянган төгрөгийн бараа материалын орлогод авсан тушаал болон тооллого томиссын тушаал, эмчийн үзлэгт хамрагдсан үзлэгийн тушаалыг шилэн дансанд байршуулж мэдээллээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 6 дугаар зүйлийн 6.4.Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.8.бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын данстай холбоотой асуудал.

Илрүүлэлт: Цэцэрлэгт хүүхдийн аюулгүй байдлыг хангах үүднээс "гараас гарт" зарчмыг баримтлан хүүхдийг өглөө багшид нь, ажлын дараа эцэг эх, асран хамгаалагчид нь хүлээлгэн өгдөг бүртгэл хангалтгүй байна.Энэ нь Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/239 тушаалаар батлагдсан "Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүчирхийлэл ертөхөөс урьдчилан сэргийлэх журам"-ын 3.5.3."Бага насны хүүхдийг заавал эцэг эх, асран хамгаалагчаас хүлээн авах, хүлээлгэн өгөх /гараас гарт/ журам" боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллана.гэсэн заалтыг хангалттай хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид холбогдох хууль тогтоомжийг баримтлан ажиллах.

2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тоног төхөөрөмжийн дансанд 1,660.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 514.9 мянган төгрөгийн бараа материал бүртгэсэн байна. Мөн бүртгэлд байгаа боловч биет тооллогоор байхгүй 7,853.1 мянган төгрөгийн хөрөнгө, бүртгэлд байхгүй ашиглагдаж байгаа хөрөнгө зэрэг байна. Энэ нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгө гэдэг нь дараах шинжтэй биет зүйлсийг хэлнэ. Үүнд:(а) Бараа, үйлчилгээний үйлдвэрлэл буюу нийлүүлэлтэнд ашиглах, бусдад түрээслэх эсвэл удирдлагын хэрэгцээнд ашиглах зорилгоор эзэмшиж байгаа; ба (б) Нэгээс дээш тайлант үед ашиглагдахаар хүлээгдэж буй, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалын " Төсвийн байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар" зэргийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид холбогдох хууль тогтоомжийг баримтлан ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан		Аудит хийгээгүй						
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			